



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 4/656

Есөнбулаг

Тэмээн сүргийг өсгөх сургалт
хэлэлцүүлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.3 дахь заалт, Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8.6 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах, ашиг шимийг нэмэгдүүлэн, тэмээ өсгөх бодлого, тэмээний өв соёлыг уламжлуулан хөгжүүлж, тэмээчдийн хөдөлмөрийг үнэлэх урамшуулах, малчдад мэдлэг мээдэлэл өгөх зорилгоор 12 дугаар сарын 14,15-ны өдрүүдэд Урд бүс Бигэр сумд (Дэлгэр, Чандмань, Цогт, Эрдэнэ), Баруун бүс Бугат сумд (Алтай, Цээл), Төвийн бүс Шарга сумд (Баян-Уул, Дарив, Жаргалан, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Есөнбулаг), 12 дугаар сарын 22-нд Есөнбулаг сумын төв Алтай хотод бүх сумууд оролцсон тэмээн сүргийг өсгөх сургалт хэлэлцүүлгийг тусгай удирдамжийн дагуу тус тус зохион байгуулсугай.

2. Уг арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Бүсийн арга хэмжээг тогтоосон хугацаанд харьяа сумдтайгаа хамтран зохион байгуулж, төлөвлөгөө боловсруулан санхүүжилтыг шийдвэрлэж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Бүсийн сумууд болон Есөнбулаг сумд зохион байгуулах арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэн, үр дүнтэй зохион байгуулж, мэдээллийг олон нийтэд сурталчилж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

5. Тус арга хэмжээний үеэр аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг ард иргэд, малчид, тэмээчдэд сурталчилан таниулах, мэдлэг

мэдээллээр хангах ажлыг тусгай хөтөлбөрөөр зохион байгуулан ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг хийж ажиллахыг Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс (С.Мөнхжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын
20..... оны дугаар сарын -ны
өдрийн дугаар захирамжийн
хавсралт

ГДСА0042

ТЭМЭЭН СҮРГИЙГ ӨСГӨХ СУРГАЛТ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	М.Алтангэрэл	(Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүдэд:	Ш.Эрдэнэбат	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
	Д.Чинзориг	(Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Л.Хаш-Эрдэнэ	(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
	Б.Мягмарсүрэн	(Хууль эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Д.Төмөрбаатар	(Цэргийн штабын дарга)
	Ж.Амгаланбаатар	(Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Р.Бүрэнбаясах	(Мал эмнэлгийн газрын дарга)
	Ж.Уранчимэг	(Биеийн тамир спортын газрын дарга)
	Э.Цагаанбаатар	(Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын хөгжлийн газар)
	Э.Отгонбаатар	(Ардын дуу бүжгийн Алтай чуулгын дарга)
	Д.Батмагнай	(Байгаль орчны газрын дарга)
	Н.Мэндбаяр	(Цагдаагийн газрын дарга)
	Ё.Нарангарав	(Аймгийн "Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв" УТҮГ-ын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Нарийн бичгийн дарга:	Т.Сүхбаатар	Сумдын Засаг дарга нар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үргийг түр орлон гүйцэтгэгч)